

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ**

2025 оны 01 сарын 07-ны өдөр

Дугаар

БА-003/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Хан-Уул дүүргийн 5 дугаар хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 5 давхар, 2 блок хүчин чадал бүхий авто худалдаа, үйлчилгээ, оффисын зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 12 сарын 13-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

- 2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний дугаар -
 - 2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЕГ Шифр: МИК-11/2022; ЕГ Шифр: МИК-03/2021, МИК-14/2021;
 - 2.3. Захиалагч: Наиен Холдинг ХХК оноосон нэр, 9011837341 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6837182 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо, Грийн хаус аос 416 тоот, холбоо барих утас: 88110909, 80020230; цахим шуудан хаяг: oyunbat880909@gmmail.com;
 - 2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: МЦХ ХХК оноосон нэр, 9011188129 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5295181 регистрийн дугаар, БУ11-17/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 6 дугаар хороо, 10-р хороолол, к106-13 тоот, 95204468 холбоо барих утас, Awroora@yahoo.com цахим хаяг;
 - 2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Цонх констракшн ХХК оноосон нэр, 9011173141 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2857286 регистрийн дугаар, МУ13-76/24 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 5 дугаар хороо, Цонх констракшн-нэс байр, 99117455 холбоо барих утас; Contat@tsonkh.mn цахим хаяг;
- Пийс Аллюминум ХХК оноосон нэр, 9011230142 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5371325 регистрийн дугаар, МУ15-068/19 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар; Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2 дугаар хороо, 2-р хороолол 69-р байр 11 тоот, 88027902 холбоо барих утас,

Урсах цэнэг ХХК оноосон нэр, 9011363138 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5629861 регистрийн дугаар, БУ11-1140/18 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 7 дугаар хороо, 70-29 тоот, 89110134 холбоо барих утас, Ursakhtseneg@gmail.com цахим хаяг;

Стронг найс констракшн ХХК оноосон нэр, 9011672103 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6183115 регистрийн дугаар, БУ19-595/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 12 дугаар хороо, Булгийн 2-1071 тоот, 88111261 холбоо барих утас;

Маредо ХХК оноосон нэр, 9011357112 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5622026 регистрийн дугаар, БУ11-592/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 12 дугаар хороо, 6 бичил Хасбаатарын гудамж, 21-50 тоот, 99114545 холбоо барих утас; tuvshinzgya@maredk.mn цахим хаяг;

Тугтангранд ХХК оноосон нэр, 9011406118 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5701414 регистрийн дугаар, 12100426 Харилцаа холбооны зохицуулах хороо Б ангилал тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 15 дугаар хороо, 39МНМТ плаза 7-704а тоот, 99117887 холбоо барих утас; info@tugtangrand.mn цахим хаяг;

У энд У электрика ХХК оноосон нэр, 9011365040 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5625122 регистрийн дугаар, 871/23 Эрчим хүчний яамны ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо, Репид харш 56, 18 тоот, 98050222 холбоо барих утас; uanduelectrika@gmail.com цахим хаяг;

Эй Би Өү Марон тиссен крупп ХХК оноосон нэр, 9011613051 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6075428 регистрийн дугаар, ӨБ12-567/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дугаар хороо, Юнион бюлдинг А корпус 15 давхар 1501 тоот, 77116868, 80057920 холбоо барих утас; info@marohn-tk.mn цахим хаяг;

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Мөнх инж констракшн ХХК оноосон нэр, 9011342038 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2819236 регистрийн дугаар, 3Т12-217/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 3 дугаар хороо, 204 тоот, 99999955 холбоо барих утас, Mik.barilga@gmail.com цахим хаяг;

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Ашиглагч: Наиен Холдинг ХХК оноосон нэр, 9011837341 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6837182 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо, Грийн хаус аос 416 тоот, 88110909, 80020230, холбоо барих утас; oynbat880909@gmail.com цахим хаяг;

Монгол Улсын иргэн Боржигон овогтой Түвшинжаргалын Баясгалан, ЧЛ81061266 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Стадион

оргил, /17012/ Их Монгол улс гудамж, 301-р байр, 1200 тоот, холбоо барих утас: 88110909, 80020230, цахим шуудан хаяг: odnuka1226@gmail.com

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэ дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 5 давхар, 2 блок хүчин чадал бүхий оффис, үйлчилгээний зориулалттай барилгын байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

- а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;
- б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

- а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;
- б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;
- в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

ТТ ШАЛГАЛТ
ГАЗАР

уламжийг аши
улах комисс

3.4. Комиссын акт 4 хуудас, хуралдааны тэмдэглэл 6 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 30 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох 1 хавтас хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1 Дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 5 давхар, 2 блок хүчин чадал бүхий авто худалдаа, үйлчилгээ, оффисын зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Хан-Уул дүүргийн 5 дугаар хороо, Наиен Холдинг ХХК-ийн захиалгатай, зорьтой 5 давхар, 2 блок авто худалдаа, үйлчилгээ, оффисын барилгаанд

Комиссын дарга: Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч:



(Б.Батчимэг)

Нарийн бичгийн дарга:
Захиалагч Наиен холдинг ХХК-ийн
Захирал



(Т.Баясгалан)


Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 5 ДҮГЭЭР ХОРОО, НАИЕН ХОЛДИНГ ХХК-ИЙН
ЗАХИАЛГАТАЙ ЗООРЬТОЙ 5 ДАВХАР, 2 БЛОК АВТО ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ,
ОФФИСЫН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр

Хан-Уул дүүргийн 5 дүгээр хороонд Наиен Холдинг ХХК-ийн захиалгатай зоорьтой 5 давхар, 2 блок авто худалдаа, үйлчилгээ, оффисын зориулалттай барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 13:00 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 14:30 цагт дуусав.



Хуралд:

1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга О.Оджаргал
2. Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилга техникийн хяналтын улсын ахлах байцаагч Н.Ёндонсамбуу
3. Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч З.Очирпүрэв
4. Барилгын хөгжлийн төв, Норм нормативын хэлтэс, Ахлах мэргэжилтэн Г.Уртнасан
5. Онцгой байдлын ерөнхий газар, Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн барилгын зураг төсөл, хяналтын ахлах байцаагч /хошууч/ Б.Даваасүрэн
6. Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчид үйлчлэх төвийн менежер Д.Болормаа
7. Үндэсний Төв архив, Зураг төслийн баримтын архив, Ахлах архивч Э.Шижиртуяа
8. Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, Улаанбаатар хотын сүлжээний газар, Ерөнхий инженер Н.Болор-Эрдэнэ
9. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Хяналт аюулгүй ажиллагааны хэлтэс, техник хяналтын инженер Ц.Билигт
10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, Хараагүй иргэдийн үндэсний холбоо Хүртээмжийн үнэлгээний ажилтан Б.Ганзориг
11. Улаанбаатар дулаан сүлжээ ТӨХК, Шинэ хэрэглэгчийн холболтын хэлтэс, Холболтын ахлах инженер М.Мөнхтөр
12. Ашиглалт хариуцсан байгууллага: Опен хаус Өнө ХХК менежер Г.Билэгсайхан
13. Ерөнхий гүйцэтгэгч: МЦХ ХХК-ийн

- захирал
14. Захиалагч: Наиен холдинг ХХК-ийн
захирал
15. Зураг төсөл зохиогч байгууллага:
Мөнх инж констракшн ХХК-ийн захирал

Ц.Ганхуяг
Т.Баясгалан
Л.Мөнхсайхан

ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 15
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 15

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хан-Уул дүүргийн 5 дүгээр хороонд Наиен Холдинг ХХК-ийн захиалгатай зорьтой 5 давхар, 2 блок авто худалдаа, үйлчилгээ, оффисын зориулалттай барилга байгууламжийн ажлын баримт бичгийн бүрдэл, барилгын ажлын гүйцэтгэл ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Нийслэлийн Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилгын техникийн хяналтын улсын байцаагч **Н.Ёндонсамбуу**:

- Барилгын тухай хуулийн дагуу баталгаа гаргаж ирүүлэх;
- Бетоны лабораторын шинжилгээ үзүүлэх;
- Өөрчлөлтийн зураг үзүүлэх, эрх бүхий байгууллагатай зөвшилцөх;
- Батлагдсан ерөнхий төлөвлөгөөг үзүүлэх;
- Барилгын ажлын зөвшөөрөл тайлбар албан тоот ирүүлэх;
- Гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгах;
- Цонхны нээлхий зай завсар гарсанг янзлах;
- Тусгай зөвшөөрөл үзүүлэх зургийн компани;
- Барилгын ажлын зураг болон загвар зураг эх хувь үзүүлэх;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд авах саналтай байна.

Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандартын хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын Ахлах байцаагч **З.Очирпүрэв**:

- Гадна дулааны худаг зургийн дагуу 2 таг хийх;
- Худгийн хүзүүг намасгаж газрын түвшинд болгох;
- 1-р барилгын узельд ус зайлуулах трапп, хаягжуулалт, хими ус цэвэрлэгээний цогц төхөөрөмж угсрах;
- Давхаруудын агаар сэлгэлтийн механик системүүдийг хэвийн ажилд оруулах (шугаманд решоткуудыг бүрэн угсрах);
- Давхруудын ариун цэврийн тоноглол бүрэн угсрах;
- Халаалтийн коллекторт хог шүүгч бүрэн угсарч хайрцаг хийх;
- 1, 2-р барилгын дээвэр дээрхи үнэр гаргагчийг малгайвчнаас дээш өндөрлөн дулаалах;
- АС-ийн шугаманд тор хийх (шахны төгсгөлд);
- 2-р барилгын зоорийн давхарт зургийн дагуу агаар сэлгэлт угсрах;



- Зоорийн давхрын халаалт түгээлтийн шугам будах;
- 1,2-р барилгын гадна ус дулааны шугамын ил далд ажлын актууд шалгуулах;
- Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй байгууллагад хариуцуулах;
- Ундны усыг шинжилгээнд хамаруулах, нөөцийн саванд ариутгал хийлгэх, эрүүл ахуйн байцаагчаар дүгнэлт гаргуулах;
- Гадна шугамыг мэдээлэлийн санд оруулсан акт шалгуулах;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд авах саналтай байна.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Шинэ хэрэглэгчийн холболтын хэлтсийн инженер **М.Мөнхтөр** :

- Техникийн бичиг баримт гадна шугам, дотор систем узелийн актууд баталгаажуулахгүй нөхөж албажуулах;
- Гадна шугам сүлжээний эзэмшлийн хамтарч хөрөнгө оруулалт хийсэн тухай зөвшилцсөн албан бичиг авч шалгуулах;
- Холболтын цэг өөрчилсөн албан бичиг үзүүлэх;
- Блок-1 Дулааны узелийн дулаалга хийх, хаягжуулалтыг сайжруулах;
- Блок-1 узельд хэрэгцээний халуун усны үзель тоноглол дутууг гүйцээж дахин шалгуулсны дараагаар хангагчтай гэрээ хийж албан бичгээр хандах;
- Блок-2 Батлагдсан зурагтай хэрэгцээний халуун усны дулаажуулалтын тоноглол угсрагдаагүй, угсралтыг иж бүрэн хийсний дараагаар хангагч байгууллагад үзүүлэн шалгуулж шийдвэрлүүлэх;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд авах саналтай байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, техникийн хяналтын инженер **Ц. Билигт** :

- Шинэ хэрэглэгчийн сүлжээнд залгах зөвшөөрлийн бичиг;
- Урд блокийн цахилгааны самбарын гүйцэтгэлийн зураг (В1 давхар);
- Хойд блок оролтын кабельд хаалт хийх;
- Цахилгааны самбаруудын кабелийн үзүүрт төгсгөвч хийх;
- 2 блок цахилгааны самбар узелийг хүрээ газардуулагад холбох;
- 2 блок техникийн давхарт хүрээ газардуулга хийх;
- Хойд блок түр тэжээл, худгийн тэжээл салгах;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд авах саналтай.

Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК, Технологийн удирдлага төлөвлөлтийн газрын Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтэсийн мэргэжилтэн **Н.Болор-Эрдэнэ**:

- Гадна холбооны акт баталгаажуулах;
- Урд барилгын камерийн хяналт, зарлан мэдээлэлийн системийг зургийн дагуу угсарч суурилуулан хэвийн ажиллагаанд оруулах;
- Хойд барилгын камерийн хяналт, зарлан мэдээлэх системийг зургийн дагуу тоноглолууд (дэлгэц, пульт, гэх мэт) суурилуулан хэвийн ажиллагаанд оруулах;
- Сүлжээний утаснуудын хаягжуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд авах саналтай.

Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчид үйлчилэх албаны Шинэ хэрэглэгчдэд үйлчилэх албаны менежер **Д.Болормаа**:

- УСУГ-тай цэвэр усаар хангах бохир ус зайлуулах аж ахуйн гэрээ байгуулах;
 - Нийслэлийн эрүүл мэндийн газарт ундны усны шинжилгээ өгч дүгнэлт гаргуулах;
 - Цэвэр усны узельд хүйтэн усны тоолуурын байрлал насосны цаана буюу ажлын талбайн зай хэмжээ байхгүй байна тоолуурын заалт авах нөхцөл бололцоогоор хангах, Тоолуурыг шилжүүлэх;
 - Номе-2-ын цэвэр усны далд ажлын акт баталгаажуулах;
 - Гадна худагт галын гидрант суурилуулах;
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд авах саналтай.

Онцгой байдлын ерөнхий газар, Гал түймэртэй тэмцэх газар, Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн барилгын зураг төсөл хяналтын тасаг хошууч **Б.Даваасүрэн:**

- ОБЕГ-ын 2022,06,07-ны 122/03-58 тоот дүгнэлтийн 2,5,6 заалтыг хийх;
 - Гал унтраах анхан шатны багаж санамж MNS5566 2020 стандартын дагуу;
 - ГК-н холбох тогоо хомут солих, ус тавьж шалгах, тэмдэг тэмдэглэгээ байршуулах
 - Галын дохиололын систем шалгасан акт, фото зураг, зааварчилгаа, 24 цагаар хүн байрлах хэсэгт төлөвлөж хийж гүйцэтгэх;
 - Зоорийн давхрын өөрчлөлтийн зургийг ОБГ-тай зөвшилцөх;
 - Гадна дулаалга болон ил далд ажлын фото зураг хавсаргах;
 - Гидрант төлөвлөх, спринклерийн хошуу шалгах, акт үйлдэх
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд авах саналтай.

Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивын ахлах архивч **Э.Шижиртуяа:**

- Архивд баримт бичиг хүлээлгэн өгөх нийтлэг жагсаалтын дагуу баримт бичгийг бүрэн бүрдүүлэх, баримт бичгийн хуудас дугаарлах, дотоод товьёг үйлдэх ;
 - Баримт бичиг болон ажлын зургийн эх хувийг архивд хүлээлгэн өгөх
 - Ил далд ажлын актыг бүрэн бүрдүүлэх баталгаажуулах;
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд авах саналтай.

Барилгын хөгжлийн төв, Барилгын материалын Үйлвэрлэлийн хэлтсийн инженер **Г.Уртнасан:**

- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасан норм нормативын сангийн төлбөрийг тооцуулан төлөх;
 - Барилгын хийц бүтээцэд хийлгүүлэн чанар аюулгүй байдлын дүгнэлт шалгуулах;
 - Гадна тохижилт ногоон байгууламж дулааны улиралд хийгдэх баталгаа албан бичиг ирүүлэх;
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд авах саналтай.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага **Б.Ганзориг:**

- Гадна автомашины зогсоолын тэмдэг тэмдэглэгээ харагдахгүй байгаа тул үзүүлэх, мөн дөрөвөөс доошгүй ХБИ-д зориулсан авто зогсоолыг төлөвлөж гүйцэтгэх (64.5 метрээс багагүй байх)

- Авто зогсоолоос явган хүний зам руу шилжих хэсэгт зориулалтын налуу гаргах;
 - Явган хүний замын ажлыг хийж гүйцээх, ба төвшингийн зөрүүгүй байх, хөтөч хавтанг стандартын дагуу суурилуулах
 - ХОМ2 барилгын орц хэсэгт 5,4 метр, ХОМ1 барилгын орц хэсэгт 7,2 метрийн урттай налуу зам хийх ба уг замын 2 талд давхар бариул хийх
 - ХБИ-д зориулсан стандартын шаардлага хангасан хүртээмжтэй ариун цэврийн өрөөг төлөвлөж гүйцэтгэх;
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд авах саналтай.

Ашиглалт хариуцах байгууллага: Опен Хаус Өнө ХХК-ийн менежер **Г.Билэгсайхан:**

- Тухайлсан саналгүй.
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд авах саналтай байна.

Зураг төсөл зохиогч Мөнх Инж констракшн ХХК-ийн захирал **Л.Мөнхсайхан:**

- 18 x 18 барилгын шилэн фасадны ажлын гүйцэтгэлийн зураг шалгуулах
- Цонхны тохиргоо цонхны тохиргоо, цонхны онгойлтын завсар зайг битүүлэх

Үүрэг даалгаврын биелэлтийг хангаж байнгын ашиглалтанд өгөх саналтай байна.

Гүйцэтгэгч байгууллага МЦХ ХХК-ийн инженер **Б.Тэргэл:**

- Тухайлсан саналгүй.
- Үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, байнгын ашиглалтанд өгөх саналтай байна.

Захиалагч Наиен Холдинг ХХК-ийн захирал **Т.Баясгалан:**

- Тухайлсан саналгүй.
- Үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, байнгын ашиглалтанд өгөх саналтай байна.

Хяналт шалгалтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга **О.Оджаргал:**

- БНБД 14-03-16 дагуу зохиогчийн хяналтын дүгнэлт бичих;
 - БТХ-ийн дагуу барилгад чанарын баталгаа гаргах;
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Хан-Уул дүүргийн 5 дугаар хороонд Наиен Холдинг ХХК-ийн захиалгатай зорьтой 5 давхар, 2 блок авто худалдаа, үйлчилгээ, оффисын зориулалттай барилгыг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэж, баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Хяналт шалгалтын газрын

Барилга байгууламжийн ашиглалт,

бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг

түр орлон гүйцэтгэгч:

(Б.Батчимэг)

Тэмдэглэл хөтөлсөн:

Наиен холдинг ХХК-ийн захирал

(Т.Баясгалан)

